

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 05 дугаар сарын 06

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 2024 оны 04 дүгээр сарын байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг дараах байдлаар үнэлэв. Үүнд:

Арга хэмжээ: Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Хэрэгжилт: “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” isf.mn системийн засвар болон нэмэлт хөгжүүлэлтийг тухай бүр хийж, хэвийн ажиллагааг хангаж байна. Тус системээр 04 дүгээр сард визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлтэй холбоотой 2939 хүсэлтийг тус тус хүлээн авч хянан шийдвэрлэсэн.Тухайн сард хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.

Энэхүү арга хэмжээ нь тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч эхэлж байгаа тул 04 дүгээр сард хэрэгжилт 90 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

Дээрх арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг бууруулахгүйгээр бүрэн хангаж, хэвийн явагддаг болсон байхад анхаарч, хөгжүүлэлтийг тогтмол хийж сайжруулах шаардлагатай.

--oo0oo--